

**Монголын боловсрол  
судлалын шинэчлэл  
өөрчлөлт, хөгжил**



**Илтгэгч: Ph.D, дэд профессор Ц.Нацагдорж**

# Нэг: Боловсролын судалгааны өв



- ☞ Монголын боловсролын үзэл баримтлал, онол, сургаал нь Энэтхэг, Түвд, Хятадаас эхтэй Ази, дорнодахины болон Орос-Зөвлөлтөөр дамжих орж ирсэн Европын боловсролын хөгжлийн онол, сургаалд суурилсан байдаг.
- ☞ Түвд, монгол болон бусад хэлээр бичиж үлдээсэн Монголын иргэний болон шашны уран зохиолын дурсгалуудад эртний Энэтхэгийн гүн ухаан, ертөнцийг үзэх үзлийн нөлөө тод мэдрэгддэг. Манай ардын аман зохиолд хүний асуудал, амьдрал, ертөнцийн зүй тогтлыг үзэх үзлийн жанжин шугам нь буддын философид тулгуурласан байдаг.

# Нэг: Боловсролын судалгааны өв



- ☞ Монгол хүний хөгжил төлөвшлийн талаар Чингис хааны сургаал гэх зарим түүхэн эх сурвалж, Товангийн сургаал, Дандаа Чинсан/Дэмчигдорж/ агсны ном, бүтээлүүдэд Күнз/Күн Цзы/-ийн сургаалын үзэл санаа, үг хэллэг элбэг тохиолдоно.
- ☞ 1905,1917 оны Оросын хувьсгалаас дүрвэж Монгол улсад дагаар орж ирсэн буриадуудын дотор Оросын СХУ-ны боловсролтой хүмүүс нэлээд байж, тэд Автономитын үеийн сургуулиудыг үүсгэн байгуулалцаж, манайд Европ зүгийн сургалтын онол, сургаал нэвтрэхэд чухал нөлөө үзүүлсэн

# Нэг: Боловсролын судалгааны өв



- 1930-аад оноос Я.А.Коменский, Ж.Руссо, К.Маркс, Ф.Энгельс, К.Д.Ушинский, В.И.Ленин, Н.К. Крупская, А.С.Макаренко, Л.С.Выготский, Г.Песталоцци, Г.Н.Волков, Ю.К.Бабанский, А.А.Сухомлинский зэрэг европ, америк зүгийн боловсролын онолчдын сургаал, бүтээл олноор дэлгэрсэн билээ.
- 1970-1980-аад оны үед Ш.А.Амонашвили, С.Н.Лысенкова, И.П.Волков, В.Ф.Шаталов, Е.Н.Ильин зэрэг ЗХУ-ын шинэчлэгч/novator/ багш нарын бүтээл, санаачлага нь тухайн үеийн багш сурган хүмүүжүүлэгчдийн дунд шинийг эрэлхийлэхэд ихээхэн түлхэц болсон билээ.

# Нэг: Боловсролын судалгааны өв



- ☞ Монгол хүн төлөвшлийн асуудлаар манай ахмад үеийн В.Инжинаш, Д.Равжаа, Тогтохтөр/То ван/, Ч.Дандаа зэрэг мэргэдийн сургаал номлол нь шинэ үеийн Ш.Гаадамба, Б.Бор, Х.Дарамбазар, Ж.Лувсандорж, Ш.Сүхээ, Л.Түдэв, Ц.Санжжав, Х.Нямбуу, Х.Сампилдэндэв, Г.Эрдэнэ-Очир, Х.Дүгэр, Д.Шагдар нарын эрдэмтдийн сурган хүмүүжүүлэх үзэл санаа төлөвших шимтэй хөрс дэвсгэр нь болсон юм.
- ☞ Дээрх өв уламжлалыг шинэчлэн хөгжүүлсэн Х.Бадамсэд, Г.Рэнцэндорж, С.Цагаан, М.Цэрэнханд, Г.Гомбожав, А.Оюунханд, Ш.Оюун, Д.Ганчимэг зэрэг бүтээлч, гавьяат багш нар тодорхой хичээлийн заах аргыг хөгжүүлэхэд үнэлж барамгүй хувь нэмэр оруулсан юм.

# Нэг: Боловсролын судалгааны өв



☞ Монгол хүний хөгжил төлөвшлийн асуудлаар Ч.Жүгдэр, Г.Сүхбаатар, Ц.Балхжав, Д.Гонгор, Б.Дашжамц, Г.Эрдэнэ-Очир, Р.Батаахүү зэрэг эрдэмтдийн судалгаа нь ХХ зууны эцэст манай оронд боловсролын үзэл санааг үндэслэх, түүний хэрэгжилтэд арга зүйн туслалцаа үзүүлэх, боловсролын хүний нөөцийг хөгжүүлэхэд үнэлж барамгүй хувь нэмэр оруулсан бөгөөд 1970-аад оны эцсээр докторын зэрэг хамгаалсан Л.Шагдарсүрэн, Д.Санжжав, Б.Даваасүрэн, Ц.Няндаг нарын бүтээлийн үнэ цэнэ онцгой билээ.

# Хоёр. Монголын боловсрол судлалын ХӨГЖИЛ



- Сүүлийн үед их сургуулиудын сургалтад болон бие даан хийж байгаа судалгаа, сургалтын бодлогод Боловсрол судлал зохих хэмжээгээр байр сууриа эзэлж эхлэв. 1993 онд МУБИС-ийн сургалтын төлөвлөгөөнд “Боловсрол судлал” хэмээх хичээл орж эхэлснээр манай орны багш бэлтгэх их, дээд сургуулиудад энэ судлагдахууныг үзэж эхэлсэн билээ.
- 1993 онд Монгол Улсын Эрдмийн зэрэг цол олгох Дээд зөвлөлөөс Ph.D-ийн зэрэг хамгаалуулах зөвлөлүүдийг байгуулахдаа “Боловсрол судлал”-аар хамгаалуулах зөвлөлийг баталснаар Монголын боловсрол судлаач эрдэмтдийн шинэ үе төрөн гарав.

# Хоёр. Монголын боловсрол судлалын хөгжил



- ❧ XXI зуун гарснаас хойш Ч.Пүрэвдорж, Д.Нямжав, Н.Бэгз, Ш.Шагдар, Х.Дүгэр, Ц.Содов, Б.Жадамба, О.Пүрэв, Р.Мягмаржав, Ц.Оюун зэрэг эрдэмтэд Боловсрол судлалын шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалав.
- ❧ БШУЯ-аас баталсан Эрдмийн зэрэг хамгаалуулах мэргэжлийн жагсаалтад өөрийн индекс бүхий “Боловсрол судлал” гэсэн бүлэг мэргэжил ордог болсон ба багшлах эрхийн шалгалтад боловсрол судлалын асуулт түлхүү орж ирдэг боллоо.
- ❧ Ийнхүү боловсрол судлал Монгол улсад богино хугацаанд шинжлэх ухааны биеэ даасан чиглэл болон хөгжиж буй боловч нийгмийн зүгээс ойлгож хүлээн авах, дэмжиж хөгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.



# Гурав. Боловсрол судлалын хөгжлийн шинэ шаардлага



- ❧ Боловсрол судлал дэлхий дахинд өнгөрсөн зууны 60-аад оноос шинжлэх ухааны бие даасан чиглэл болон шинэ хандлагаар хөгжиж байна.
- ❧ Дэлхийн олон оронд боловсрол судлалын хүрээлэн, их дээд сургуулиудад боловсрол судлалын тэнхим байгуулагдаж боловсролын өргөн хүрээний асуудал судалдаг боллоо.
- ❧ Боловсрол нь хүн төрөлхтний олон арав, зуу, мянган үеийнхний буй болгосон амьдрах соёлыг дараа дараагийн үед нь өвлүүлэн дамжуулах нийгмийн институц юм.

# Гурав. Боловсрол судлалын хөгжлийн шинэ шаардлага



- Шинэ XXI зууны босгон дээр боловсрол нь хүн төрөлхтний хөгжлийн үндсэн хүчин зүйл, түүний зайлшгүй шаардлагатай орчин болж байна. Өөрөөр хэлбэл XXI зуун бол мэдлэгт суурилсан зуун болно гэж шинжлэх ухааны хүрээнд үзэж байна.
- АНУ, Герман, БНСУ, Австрали зэрэг өндөр хөгжилтэй нэлээд орнуудад багш бэлтгэх сургуулийн сургалтын агуулгын 50-70 хувь нь боловсрол судлалд суурилсан багшийн эрдмийн судлагдахуунууд эзэлж байна. Энэ нь боловсролын онол, арга зүйн мэдлэг сайтай, багшлах өндөр ур чадвартай багш бэлтгэх үндэс болдог байна.

# Гурав. Боловсрол судлалын шинэ шаардлага



- ☞ Боловсрол судлал нь байгалийн шинжлэх ухаан, нийгмийн шинжлэх ухааны уулзвар дээр үүссэн ХҮН СУДЛАЛЫН бүлэг шинжлэх ухааны нэг салбар болж, бие даан хөгжиж байна.
- ☞ Боловсрол судлалыг англи хэлт орнуудад **education, research**, Герман болон түүний төрөл хэлт орнуудад **Pedagogika** гэж нэрлэдэг байна. 1962 оноос **EDUCOLOGY** гэж нэрлэхээр тогтсон ч дээрх 3 нэр зэрэгцэн хэрэглэгдсээр байна.

# Гурав. Боловсрол судлалын шинэ шаардлага



- ☞ Хүний амьдралын тодорхой үе шатны физиологийн суурь хэрэгцээний дагуу боловсролын хэрэгцээ насны үечлэлээрээ 3 өөр үе шатанд хуваагдаж тус тусдаа ялгаа бүхий нэр томъёогоор илэрхийлэгдэх болов.
- ☞ Педагогика хэмээх нэр томъёо Сурган Хүмүүжүүлэх Ухаан гэж XVIII зууны үеэс эхлэн хэрэглэж ирсэн ба хүүхдийг сургах ажлыг чиг зорилготой явуулж буй процесст хамаарах ойлголт юм.
- ☞ Андрогогика хэмээх нэр томъёо нь **андр**-насанд хүрсэн хүнийг сургах гэсэн утгатай грек үг бөгөөд андрогогика нь мэдлэг гэдэг утгаараа насанд хүрэгчдийн боловсролын хүрээнд хамаарсан мэдлэг, процесс гэдэг утгаараа “насанд хүрэгчдэд явуулж буй үйл явц юм. Насанд хүрэгчдийн боловсрол нь дэлхийн олонх оронд голдуу мэргэжлийн боловсролын тасралтгүй сургалтын хэлбэрээр явагдаж байна.

# Гурав. Боловсрол судлалын шинэ шаардлага



- ☞ Грек хэлний **герон-онтос** /хөгшин хүн/ гэсэн үгэнд **гогика** залгаж **геронтогика**-өндөр настны сургалтын онол гэсэн нэр томъёог сүүлийн үед боловсрол судлалын ном зохиолд хэрэглэж байна. Эдгээрийг дурьдсаны учир утга нь өнөөгийн сургуулийн эрхэм зорилго нь нийгэмд насан туршийн боловсрол олгоход чиглэгдэх ёстой болж байна.
- ☞ Харин манай багш, судлаачид, удирдах ажилтнуудын Боловсрол судлалын шинжлэх ухааны талаарх ойлголт тааруу дутмагаас болж, Боловсрол судлалын шинжлэх ухаан, Хүүхдийг сургаж хүмүүжүүлэх ухаан, Насан туршийн боловсролын онол арга зүйг хольж хутгах, зөвхөн педагогика-аар орлуулж ойлгох хандлага хэвээр байсаар байна. Бүр эцэстээ Боловсрол судлалыг Хүүхдийн сурган хүмүүжүүлэх ухаанаар төлөөлүүлж ярьж бичихэд хүрээд байна.
- ☞ Багш бэлтгэх сургуулийн мэргэжлийн хөтөлбөрт Боловсрол судлалын нэрээр Хүүхдийн СХУ-ыг заах түүгээр ч барахгүй Боловсрол судлалыг Педагогикагийн дотор оруулж төөрөлдөх явдал ч байсаар байна

# Гурав. Боловсрол судлалын шинэ шаардлага



- ☞ Монголын боловсрол судлалын шинэ үеийн зорилт нь:  
Глобаль нээлттэй орчинд үндэснийхээ соёл, уламжлал, зан заншлын дэвшилттэй ололтыг бататгаж, өндөр хөгжилтэй бусад ард түмнүүдээс суралцах замаар эх орныхоо боловсролын хөгжлийг олон улсын боловсролын нийтлэг жишигт нийцүүлэн хөгжүүлэхэд оршино. Үүний тулд:
- ☞ Боловсрол судлалыг судалгааныхаа тэргүүлэх чиглэлийн зиндаанд тавьж сурталчлах, тодорхой бүтэцтэй болох зайлшгүй шаардлагатай байна
- ☞ Судалгааны орчин үеийн аргад мэргэжилтнүүдээ сургахын тулд ОХУ, БНХАУ, БНСУ-тай хамтран ажиллаж суралцах шаардлага зүй ёсоор тавигдаж байна

# Гурав. Боловсрол судлалын шинэ шаардлага



- ❧ Боловсрол судлалын салбар бүрээр шавь сургалт бий болгох, мэргэжилтэн судлаачдыг мэргэшүүлэн бэлтгэх
- ❧ Судалгаа, мэдээллийн эх үүсвэрийг олж авах боломжоо нэмэгдүүлэх, судлаачдын гадаад хэл, компьютерийн боловсролыг дээшлүүлэх
- ❧ Багшийн ангийн сургалтын хөтөлбөрт Боловсрол судлалын шинжлэх ухааны орчин үеийн онол практикийн асуудлуудыг илүү тусгах, сурах бичиг, гарын авлага бэлтгэж хэвлүүлэх нь багш бэлтгэх ажлын чанарыг ихээхэн дээшлүүлэх ач холбогдолтой юм.

# Гурав. Боловсрол судлалын шинэ шаардлага



- ☞ Монголын боловсролын өөрчлөлт, шинэчлэлт, хөгжлийн судалгаа 1911-2011 сэдэвт үндэсний хэмжээний суурь судалгааны арга зүй боловсрогдсон байна.
- ☞ Эрхэм хүндэт багш таны Боловсрол судлалын чиглэлээр судалгааны ажил хийх зам тань ногоон гэрэлтэй байна.





**Анхаарал тавьсанд  
баярлалаа**